

**Б.РИНЧЕНГИЙН “МОНГОЛ ШҮЛГИЙН УЧИР” (1970)
ӨГҮҮЛЛИЙН ШИНЭЛЭГ ҮЗЭЛ САНАА**

Г.Галбаяр
/МУИС/

Монгол түмнийхээ соёл иргэншил, аж амьдрал, эрдэм ухааны үнэт зүйлийн охь дээжээс суралцаж, сурвалжлан цуглуулж, судлан шинжилж, хойч үеийн бидэнд үнэ цэн, үнэн учрыг нь нээн өгсөн нэгэн бол эрдэмтэн Б.Ринчен билээ. Б.Ринченгийн монголын уран зохиол судлалын хүрээнд бичсэн бүтээлүүдийн нэг нь “Монгол шүлгийн учир” өгүүлэл юм. “Монгол шүлгийн учир” өгүүллээ ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлсэн ХЭЛ ЗОХИОЛ СУДЛАЛ сэтгүүлийн 1970 оны VII (17-102 дугаар тал), VIII (5-50 дугаар тал) ботид хэвлүүлжээ. Шүлэг нь туурвигч үндэстнийхээ хэл-сэтгэхүйн цөм ухагдахууныг уран сайхны сэтгэлгээний дээд эрэмбэт төгс дүрслэлээр илэрхийлж биелэлээ олдог зүйл. Монгол шүлгийг монгол үндэстний уран сайхны сэтгэлгээ (дүрслэл), монгол хэл бичгийн зүй тогтол (найруулга)-ын илэрхийлэл гэж онцлон авч үзээд цогцоор нь судлан шинжилснээрээ “Монгол шүлгийн учир” өгүүлэл чухал ач холбогдолтой. Иймээс монгол шүлгийг ямар нэг хэмжээгээр судлан шинжилж, зарим талын онцлог, мөн чанарыг үнэн мөнөөр нь нээн буй энэ цаг үед Б.Ринченгийн “Монгол шүлгийн учир” өгүүлийн судалгааны арга зүй, ололт амжилт, шийдсэн шийдлийг бататган гүнзгийрүүлж, лавшруулан судлах нь чухал ач холбогдолтой ажлын нэг болоод байна.

Б.Ринченгийн “Монгол шүлгийн учир” өгүүлэл I. Ерөнхий тэмдэглэл, II. Авиа үсэг хоёрын учир, III. Монгол хэлний үеийн бүтэц, IV. Шүлгийн хоёр ёсны учир, V. Холбоц, VI. Монгол бичгийн шүлгийн зарим байдлаас гэсэн үндсэн зургаан хэсэгтэй ажээ. Монгол шүлгийн ерөнхий онцлогийг монголчуудын түүхэн замнал, соёл иргэншил, аж амьдрал, сэтгэлгээний онцлогтой уялдуулан авч үзэхдээ монгол хэлний авиа үсгийн харьцаа, үеийн бүтэц, зүй тогтолтой давхар холбож хүн төрөлхтний нийтлэг шүлгийн тогтолцоо, бүтэцтэй харьцуулан судалсан байна.

НЭГ: ЕРӨНХИЙ ТЭМДЭГЛЭЛ

Гол өгүүлсэн зүйл: Б.Ринчен “Монгол шүлгийн учир” өгүүлийнхээ эхэнд “Монголын Нууц Товчоо” тэргүүтэй монголын түүхэн сурвалж бичгүүдээс үзвэл *“монголчууд толгой холбосон үг, шүлэглэл их хэрэглэдэг байсан байна. ... одоо хүртэл манай ардууд уран цэцэн үгэнд их дуртай, толгой сүүл холбон хэлэлцдэг нь нийтийн заншил байгааг дурдаж болно”* /VII. 17 дугаар тал/ гэж монголын ард түмний зан заншил, соёл сэтгэлгээний онцлогийг тэдний туурвин үлдээсэн шүлэг найрагтай уялдуулан өгүүлээд гадны бусад улс үндэстний шүлэг найргийг монгол хэлнээ хөрвүүлэх ёс уламжлал дүрэм журмын тухай тодруулан авч үзжээ. Тухайлбал, төвөд хэлнээс монгол хэлнээ шүлэг орчуулахад баримтлах ёсны тухай

өгүүлсэн “Мэргэд гарахын орон” гэдэг төвөд монгол нэр томъёоны толь бичигт “Бус бас монголын хэлэндүр шүлэглэсэн хийгээд үргэлжилсэний ялгал ба шүлэгтүр ч бадаг урт охор тэгш болох тэргүүтэн төвөдийн хэл ямбарчлан эс болбаас бээр, шүлэглэснүүдий нь яруу найртай утга төгс, мэдэхүйеэ хялбар бадгийн урт охорыг ч олонхиныг тэгш үйлдэх бөгөөд магтаал хийгээд залбирал мэт заримуудтур монгол хэлэндүр адилхсан толгой холбох мэт үйлдвээс бээр харигүй боловч, их голнуудтур тэр мэт үл үйлдэх бөгөөд бусцар болбаас олон илүү үгс орсноор утга далдлагдахын тул болой.

Бус бас дохио найруулахын гол энэ хийгээд бусдаа эс гарсан дохиог шинэ найруулах хэрэгтэй болбаас, өөр өөрийн газраа дураар зориг мэдэн нэрийдэл үгүүеэ орчуулахын хүрээндүр тулгаж, гол ба учир шалтгаан лугаа харишуулал үгүүеэ орчуулагдахуй. Тэдгээр ину шалтгаан өгүүлэх хийгээд ном орчуулах ёсыг цаазлан тогтоосон товчийн төдий болой” /VII. 17-18 дугаар тал/ гэснийг тусгайлан авч тайлбарласан байна. Энэ нь төвөд монгол үгийн дэс дараа нь өөр учраас монгол хэлнийхээ ёсонд нийлүүлж, үгийн байрыг солихын мөн чанарыг өгүүлжээ. Энэ мэтээр гадаадын хэлнээс тэдний шүлэг найргийг монгол хэлнээ хөрвүүлэхдээ үнэ цэнтэй онцлог шинжийг нь алдагдуулалгүй хэрхэн буулгах арга зарчмийг тодорхой болгоход монгол шүлгийн өөрийнх нь зүй тогтлыг нэн тэргүүнээ судлан шинжилж тодорхой болгох ёстойг асуудал болгон дэвшүүлжээ. Уг асуудалтай холбоотойгоор монгол шүлгийг судлан шинжилсэн Габеленц, Ковалевский, Владимирцов, Крюгер, Туденов, Б.Содном нарын зэрэг гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын судалгаа шинжилгээний үр дүнгээс танилцуулжээ.

Шийдэл: Гадаадын бусад орны шүлэг найргийг монгол хэлнээ орчуулахад тухайн шүлгийн онцлогийг алдагдуулахгүй байх ямар арга зарчим байж болохыг авч үзэх, улмаар монгол шүлгийн гадаад, дотоод зүй тогтлыг тодруулахын чухлыг асуудал болгон дэвшүүлсэн байна.

ХОЁР: АВИА ҮСЭГ ХОЁРЫН УЧИР

Гол өгүүлсэн зүйл: Хүн төрөлхтөн “утга үсэг, авианы үсэг –ийм хоёрхон зүйлийн үсэг хэрэглэн буй” /VII. 30 дугаар тал/ Утга үсэг гэгч нь нэг үгийг нэг тэмдэгтээр тэмдэглэдэг бол авианы үсэг гэгч нь нэг үгийг хэд хэдэн эгшиг, гийгүүлэгчийн хослолоор тэмдэглэдэг. Эгшиг, гийгүүлэгчүүдийн хослолоор бүтэх авианы үсэг нь үндэстний сэтгэлгээ, соёл, зан заншлаас хамааралтай шинжлэх ухааны үндэслэлтэй үсгийн, зөв бичих зүйн, зөв дуудах зүйн дүрэмтэй байдаг байна.

Судлаач Б.Ринчен “Авиа үсэг хоёрын учир” гэсэн энэ хэсэгтээ монгол хэлний үсгийн дүрэм, зөв бичих зүйн зүй тогтол, зөв дуудах зүйн уялдаа холбоо, учир шалтгааныг тайлан тайлбарлажээ.

Үсгийг хэрхэн зөв дэс дарааллаар бичихийг үсгийн дүрмээр шийдвэрлэдэг бол үгийг хэрхэн зөв бичих ёсыг зөв бичих зүйгээр шийдвэрлэдэг. Зөв бичих зүй нь тухайн хэлний онцлог мөн чанар, зүй тогтолд үндэслэгдсэн байдаг байна. Монгол хэлнээ үсгийг хэрхэн зөв бичих үсгийн дүрэм, түүнээс урган гарсан үгийг зөв бичих зөв бичих зүй нь гурван янз байна. Нэгдүгээр зарчим нь авиан зүйн зарчим. “Тэр ёсоор нэгэн хэсэг үгийг өгүүлэхийг баримтлан бичих журам болно. Ганц үеэр бүтсэн үг, үгийн үндэс, язгуурын зүйлд хэрэглэнэ. Гар, хөл гэх мэтийг авиан зүйн зарчим баримтлан(х) зөв бичих зүйн ёс буй.” /VII. 41 дүгээр тал/ Хоёрдугаар зарчим нь хэлбэр судлалын зарчим. “Соёл өндөр улсын зөв бичих зүйд үг дахин бүтдэгийг хэлний шинжлэлтэн, тухайн хэлэнд ямар утгаар, дагавар

зэргийн үг бүтээгч зүйл буйг шинжлэн ялгаж, тус бүрийн зөв бичих журмыг тогтоон, тогтмол тэр угтвар, дагавар зэргийн залгавар нь язгуурт хойно урд нь орохдоо шинэ үг бүтээдэг нь цөм хэлбэр судлалын үүднээс дүрэмтэй байдаг тул, эл хоёрдугаар журам нь зөв бичих зүйн гол зарчим байдаг байна.” /VII. 41 дүгээр тал/ Авиа сэлгэн үг бүтээх ёсыг энэхүү хэлбэр судлалын хүрээнд шийдвэрлэдэг болохыг тодруулан жишээ баримтаар баталгаажуулан тайлбарлажээ. Гуравдугаар зарчим нь уламжлалт зарчим. “Бусад хэлнээс орсон үгийг тэдгээр хэлний журмыг нь уламжлан бичих зүйл болно.” /VII. 42 дугаар тал/ Сайн боловсорсон хэлний зүй тогтол тэр дундаа авиа үсэг хоёрын зарчимтай холбоотойгоор үсэг яаж тэмдэглэх үсгийн дүрэм, үг яаж бичих зөв бичих зүйгээс урган зөв дуудах зүйн тухай ойлголт гардаг. Хүн хэдий чинээ боловсрол мэдлэгтэй болно төдий чинээ бусадтай харилцах шаардлага урган гарна. Тэрхүү шаардлагыг хангахад харилцах хэлнийхээ зөв дуудах зүйд сайн суралцах хэрэгтэй. Энэ нь зөв дуудах зүй шинжлэх ухааны үндэслэлтэй боловсрогддогийн гэрч. Харин монгол хэлний зөв дуудах зүйн асуудлыг манай хэлний шинжлэлийн эрдэмтэд даруй шийдвэрлэхийг асуудал болгож сөхөн тавьжээ.

Шийдэл: Үсгийг зөв бичих үсгийн дүрэм, үгийг зөв бичих зөв бичих зүйн дүрэм, үгийг зөв дуудах зөв дуудах зүйн асуудал харилцан холбоо хамаарал бүхий тус тусдаа үүрэг зорилго бүхий зүйлс ч тухайн хэлээр шүлэг бичих суурь хөрс болох учир шүлэгч хүн өөрийн хэлнийхээ зүй тогтол, онцлогийг язгуур мөн чанараас нь сайн судлан шинжилж мэдэх, төгс сайн суралцах шаардлагатай байдгийг өгүүлжээ. Үсгийн дүрэм, зөв бичих зүй, зөв дуудах зүй нь дотооддоо шинжлэх ухааны үндэслэлтэй нарийн зүй тогтолтой байх тул шүлэгч, орчуулагч хүн түүнийг сайн мэдсэн байх нь сайн шүлэг бичих, сайн орчуулга хийх гол үндэслэл болно.

ГУРАВ: МОНГОЛ ХЭЛНИЙ ҮЕИЙН БҮТЭЦ

Гол өгүүлсэн зүйл: Үг үеэр бүтнэ. Үгийн үеэр бүтэх зүй тогтол хэл хэлэнд өөр өөр байх ч нийтлэг шинж нь эгшиг, гийгүүлэгч хоёрын хоорондын найран орох байдлаас шууд хамааралтай. Монгол хэлний үеийн бүтцийн тогтолцоог эрдэмтэн мэргэд судлан шинжлээд доорх 4 зүйлийн зүй тогтол байна гэж тогтоосон байна. Үүнд:

- | | |
|--|--------|
| 1. Эгшгээр бүтсэн үе | -Э |
| 2. Эгшиг гийгүүлэгч хоёроос бүтсэн үе | -Э+Г |
| 3. Гийгүүлэгч эгшиг хоёроос бүтсэн үе | -Г+Э |
| 4. Гийгүүлэгч, эгшиг, гийгүүлэгч гурваас бүтсэн үе | -Г+Э+Г |

“Энэ дөрвөн зүйлийн үеэр манай хэлний эрт одоогийн бүх монгол үг, монголын эрт одоогийн бүх хэл аялгуунаа бүтсээр иржээ.” /VII. 50 дугаар тал/

Эгшгээр бүтсэн үе (Э)-д ганц ерийн эгшиг юмуу ганц урт эгшиг байж болдог. “Чингэхдээ монгол хэлний нэгэн онцлог нь гэвэл, нэгэн үгнээ чанга буюу эр эгшиг, эсвэл сул буюу эм эгшиг орохоос, эр эм эгшиг нэгэн үгэнд хутгалдан ордог журам үгүй тул үгийн эхний үеийн эгшиг нь эр байвал цаашаа дан эр эгшиг болно. Үгийн эхний үеийн эгшиг нь эм эгшиг байвал тэр үгийг найруулан бүтээсэн бүх дагаврын эгшиг нь цөм эм эгшиг байдаг журамтай. Чингэхдээ саармаг буюу эрс гэдэг и эгшиг бүхгүй үе, эр эгшигт үеэр эхэлсэн үгнээ оролцож болно. Мөн эм эгшигээр эхэлсэн үгийн дараачийн үед ч эл саармаг и эгшиг эгшигтэй үед орж болно. ... Энэ бол монгол хэлний эгшиг зохицохын хууль болой” /VII. 51 дүгээр тал/ Монгол хэлний хос эгшиг эр, эм гэж байх тул дээрх хуульд шууд захирагдана. Хоёр өөр үг угсрах аваас энэ хууль үйлчлэхгүй. Учир нь хоёр өөр үг угсрах нь өгүүлбэр зүйн

асуудал юм.

Монгол шүлэг монгол бичгийн хэлний зүй тогтлоор бичигддэгийн хувьд олон монгол хэл аялгууны дундын хувилбараар бичигдэж, зөвхөн тэдний дуудах дуудлагаар ялгарах энэ онцлогтой нарийн холбоо хамааралтай. “Учир нь юувэ? гэвэл шүлгийн хэм хэмжээг нь алгасалгүй нарийн баримталж бичсэн буюу орчуулсан бол цаад уг хэлний шүлгийн хэм хэмжээг ширхэгийн төдий өөрчлөлгүй нарийн буулгаж орчуулсан зүйл цөөнгүй тохиолдмуй. Чингээж нарийн хэм хэмжилтэй зохиосон монгол шүлэг бол орчин үеийн европын сайн яруу найрагч нарын хэрэглэдэг нарийн журамтай яг нийлэх өндөр боловсролтойн гэрч бөгөөд бусад хэлнээс орчуулсан шүлгийн зохиолд уг эх хэлний сайн зохиосон нарийн хэм хэмжээг нь шад тутамд алдалгүй буулгаж чадсан нь бас л манай яруу найрагч нарын сүрхий чадал, өндөр боловсролыг нь харуулж, олон улсын одоо хэрэглэж журам болгодог сонгодог нарийн арга барилгыг аль хэдийн мэдэн эзэмшсээр ирсэний бахархалтай гэрч болой.” /VII. 57-58 дугаар тал/ Монгол хэлний үеийн бүтэц, эгшиг зохицох хуультай уялдаатайгаар монгол шүлгийн олон янзын онцлог бий болсон байдаг байна.

Монгол хэлний үеийн бүтэц үүсэх Э+Г, Г+Э+Г гэсэн зарчимтай холбоотой үүсэх монгол хэлний гийгүүлэгч дэвсгэрлэх ёс, улмаар үеийн төгсгөлийн “дэвсгэр” авиа монгол шүлгийн урлалд хэрхэн нөлөөлснийг авч үзжээ.

Дэлхийн олон орны хэлэнд түгээмэл байх үеийн бүтцийн онцлогийг дэлгэрэнгүй тайлбарлаж, тэрхүү үеийн бүтцээр бичигдсэн шүлэг зохиолыг хэрхэн монгол хэлнээ орчуулах тухай авч үзсэн нь бий.

Шийдэл: Монгол хэлний үеийн бүтэц дөрвөн янзаар үүсэх ч эгшиг зохицох хуулинд захирагддаг онцлогтой. Монгол хэлний эгшиг зохицох хууль шүлэгт нэг мөрийн хэмжээнд үйлчлэх зүй тогтол үүсгэдэг. Энэ нь монгол шүлгийн гол онцлогуудын нэг болно. Монгол шүлэг монгол хэлний үеийн бүтцийн зүй тогтол, монгол бичгийн хэлний зөв дуудах зүй /Владимирцовын ажигласнаар монгол бичгийн хэлний дуудлага гурван янз байна/-н журмын дагуу хэм хэмнэл үүсдэг байна. Өөрөөр хэлбэл монгол шүлгийн нэг онцлог нь мөр хоорондоо нарийн хэм хэмнэлтэй байх явдал юм. Мөр хоорондын хэм хэмнэл жигд байх нь шүлгийг уянгалаг сайхан сонсогдуулах төдийгүй олон янзын үнэт шинжийг агуулж оршдог билээ. Монгол хэлний гийгүүлэгч дэвсгэрлэх ёс нь монгол шүлгийн мөр хоорондох үеийн тооны тэнцэл, холбоцын зарчимд чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

ДӨРӨВ: ШҮЛГИЙН ХОЁР ЁСНЫ УЧИР

Гол өгүүлсэн зүйл: “Энэтхэг төвөд номын хэлтэй монгол бичгийн хүмүүсийн шүлэгт хэм хэмжээний тухайд маш нарийн зохион байгуулалттай байдаг нь европ зүгийн яруу найргийн онол, шүлэг зүйтэй нийцэх зүйл үлэмж учир энэ бүлэгт европын шүлгийн ёс, түүнээ хэрэглэдэг нэр томъёог нь шүлгийн тухай сонирхох монгол уншигчдаа танилцуулж өгвөл зохих байнам. Үүнд европ шүлэг зүйн нэр томъёо нь грек-латин номын хэлээр занисан зуриил грек-латин соёлын хүрээний европ зүгийн улс түмнээ буй. Үүнд энэтхэг, төвөд номын хэлний уламжлал бүхүй монгол хэлнээ грек-латин нэрийг нь орчуулж нэгэн мөр болговол үл болох газар үгүйн дээр бусад улс, тэдгээр нэрийг өөрийнхөө хэлэнд орчуулан хэрэглэсээр ирсэн. Үүнд цөмийг нь монгол үгээр орчуулахад эртний грек буюу латин үгтэй онолдох үг монгол хэлнээ нэгэнт буйн учир үг нь монгол, утга санаа нь нийтийн байвал зүйтэй бий гэж монгол болгон буулгаж хэрэглэлээ.” /VII. 89 дүгээр тал/ Грек-латин хэлний өрнөдийн сонгодог шүлэг үеийн урт богиноор хэмжээ болгодог учир энэ шүлгийг хэмжээт шүлэг гэж нэрлэж заншжээ. Нэг богино эгшиг бүхий үеийг дуудахад

зарцуулах цагийг үндэс болгож *хронос* буюу *язгуур цаг* гэж үздэг байна. Хоёр язгуур цаг нийлээд нэг урт үеийг үүсгэнэ. Энэ үндсэн хэмжээг латинаар *мора* буюу монголоор *түдэл* гэж нэрлэдэг байна. Өрнөдийн шүлэг урт богино үе найран орж тусгай хэмжээ үүсгэдэг байна. Үүнийг грекээр *поус*, латинаар *пес* гэж нэрлэдэгийг англиар *Foot*, францаар *Pied*, оросоор *стопа* гэж нэрлэдгийг монголоор *өлмий* гэж орчуулж заншжээ. Богино урт үе нийлж өлмий үүсгэх тул энэ нь шүлгийн үндсэн нэгж болдог гэсэн үг.

Шүлгийн хоёр дахь ёс нь өргөлтөт шүлгийн ёс юм. Энэ шүлгийн ёсоор бол шад хоорондын үеийн тоо тэнцүү байхыг гол болгох ч шадын хоорондох өргөлттэй, өргөлтгүй үеийн тоог жигдлэхийг чухалчлах ажээ. Монгол хэлнээ өргөлттэй өргөлтгүй үе байх тул энэ шүлгийн ёс давамгайлдаг талтай. Тиймд монгол шүлгийг үе өргөлтөт шүлэг гэж судлаач Б.Ринчен үзсэн байна.

Энэ бүлэгт цааш нь өрнөдийн хэмжээт шүлгийн үндсэн нэгж болох дэвхцэл, бүжил, сацаль, пириг гэх хоёр үет өлмий, хуруун, хосмолжин, тонгорол, хөлчил, тонгоруу хөлчил, гурван уртат, гурван богино, крит гэх гурван үет өлмий, зөрүүлбэл, йоны, бадранга, гурамсан, бүжил дэвхцэл гэх дөрвөн үет өлмий, уужим гэсэн таван үет өлмийн бүтэц зүй тогтлыг тайлбарлаж жишээ баримтаар үзүүлсэн байна.

Шийдэл: Шүлэг бол тогтолцоотой хэм хэмжээт зохиол. Хэм хэмжээтэй зохиолыг хүн төрөлхтөн ерийн ярианы адил уншдаггүй заавал уянгалуулан эгшиглүүлж хэлдэг байна. Энэ нь шүлэг найраг хүний сэтгэл зүрхэнд хурцаар хүрч, тэдэнд хүчтэй нөлөө үзүүлдэгтэй холбоотойг илрүүлсэн хэрэг.

Монгол хэлээр шүлэглэхэд өрнөдийн хэмжээт шүлгийн бүхий л бололцоо нөөцийг тусгах боломж байгааг судлаач ажигласан байна. Өөрөөр хэлбэл монгол шүлэгт өрнөдийн хэмжээт шүлгийн бүхий л үнэт зүйлсийг тусган орчуулах, бас шинээр хэмжээт шүлэг зохиох бололцоотой аж. Судлаачийн үзсэнээр бол монгол шүлэг нь үе-өргөлтөт шүлгийн ёсыг түгээмэл хэлбэрээр хадгалдаг байна.

ТАВ: ХОЛБОЦ

Гол өгүүлсэн зүйл: Монгол шүлэг бичихэд, улмаар гадны шүлгийг эх хэлнээ төгс сайн орчуулахад шүлэгч, орчуулагч хүний мэдвэл зохих асуудлын нэг бол шүлгийн холбоц гэдэг нэгэн ёсны чимэлгэн буйг бодолцох учиртай. *“Хоёр шад холбох нь наад зэргийн зүйл бөгөөд олон шад шүлэгт олон арга хэрэглэн холбодог тэр холбоц болбол, шадын эх буюу сүүлийг дуудлага адил төслүү байдлаар холбох чимэг болно. Үүнд монгол хэлнээ үлэмжид дэлгэрсэн нь шадын толгой холбох холбоц ажээ. Тэр учраас, зарим европ хүний монгол шүлгийн тухай бичсэн зүйлд монгол шүлэгт гагцхүү толгой холбох холбоц буй гэж бичсэн зүйл ч бий”* /VIII. 12 дугаар тал/ гэж бичээд *“Толгой холбох эл чимгийг тэр байдлаар нь нэрлэвэл, наад зах нь хошоод шадын толгой холбосныг толгой холбоц хэмээмүү. Хоёр буюу хэд хэдэн шадын сүүлийг холбосон зүйл бас монгол шүлэгт байдаг, түүнийг уг байдлаар сүүл холбоц хэмээмүү”* /VIII. 12 дугаар тал/ гэж монгол шүлгийн толгой, сүүл холбох ёсыг тодотгон өгүүлсэн байна.

Монгол шүлгийн толгой, сүүл холбох ёс нь шүлэгт чимэг оруулах давхар үүрэгтэй. Гадны олон улс орны шүлэгт толгой, сүүл холбох ёс өөр өөрийн гэсэн үүрэгтэй байдаг. Тэднийг монгол шүлэгт орчуулахдаа холбоцын төрөлх онцлогийг нь хадгалж монгол хэлнээ хөрвүүлэх бүрэн бололцоотойг орос, франц зэрэг шүлгийн жишээ баримтад тулгуурлан авч үзжээ. Монгол шүлэгт толгой холбох ёс тэргүүлдэг. Европ дахины шүлэгт сүүл холбох ёс тэргүүлдэг. Монгол, Европ

дахины шүлгийн ёсны холбоц ийм ч европ шүлгийг монгол хэлнээ орчуулахдаа тэргүүлэх үүрэгтэй сүүл холбоцыг толгой холбоц болгож, монгол шүлгийг европын хэлэнд орчуулахдаа тэргүүлэх үүрэгтэй толгой холбоцыг сүүл холбоц болгон хувиргаж орчуулах боломжтойг жишээ баримтад тулгуурлан тайлбарлажээ. Шүлгийн холбоцыг байрлалаар нь ялган нэрлэдэг уламжлалт аргын дагуу:

-Зэрэгцэх холбоц

Байр	Тодорхойлолт	Томъёолол
толгой	Зэрэгцээ байгаа хоёр шад нэгэн холбоцтойг тийнхүү нэрлэх бөгөөд, хэд хэдэн ч шад дараа дараагаар, завсар дунд нь өөр төрлийн холбоц ороогүй, цөм нэгэн холбоц бүхийг цөм зэрэгцэх холбоц хэмээмүй. Зэрэгцэх холбоц толгой, сүүл холбоцонд адил тохиолдоно.	- AA
сүүл		- AAAA - AABV

-Салаавчлах холбоц

Байр	Тодорхойлолт	Томъёолол
толгой	Нэг шад алгасан холбох холбоц. Дөрвөн шад бүхий шүлгээс эхлэн үзэгдэнэ. Салаавчлах холбоц толгой, сүүл холбоцонд адил тохиолдоно.	- AVAV
сүүл		

-Хаших холбоц

Байр	Тодорхойлолт	Томъёолол
толгой	Дөрвөн шад шүлгийн эх адгийн шадыг нэгэн холбоцоор холбох холбоц. Хаших холбоц толгой, сүүл холбоцонд адил тохиолдоно.	- AVVA
сүүл		

-Оодон холбоц

Байр	Тодорхойлолт	Томъёолол
толгой	Нүднээ үзэгдэж, чихнээ сонсогдох нэг эгшиг юмуу нэг гийгүүлэгчээр ил өнгөн холбосон холбоц. Оодон холбоц зэрэгцэх, салаавчлах, хаших холбоцын бүх онцлогийг хадгална.	- AA
сүүл		- AAAA - AABV - AVAV - AVVA

Б.Ринчен өгүүллийн энэ хэсэгтээ монгол шүлэг дэх авиа давтах үзэгдлийн тухай товч тайлбар хийжээ. Авиа давтан шүлгийн утга санаанд хүч нэмэгдүүлэхийн зэрэгцээ шад хоорондын хэм хэмнэлийг тэгшитгэх үүрэгтэй хэрэглэгддэг онцлогтой ажээ.

Шийдэл: 1. Монгол шүлэгт толгой холбох ёс тэргүүлэх үүрэгтэй. Европ дахины шүлэгт сүүл холбох ёс тэргүүлэх үүрэгтэй. Гэхдээ монгол шүлгийг европын хэлэнд орчуулахад тэргүүлэх үүрэгтэй толгой холбоцыг тухайн хэлний шүлгийн тэргүүлэх үүрэгтэй сүүл холбоц болгож, европын хэлний шүлгийг монгол хэлнээ хөрвүүлэхдээ тэргүүлэх үүрэгтэй сүүл холбоцыг монгол хэлний шүлгийн тэргүүлэх үүрэгтэй толгой холбоцоор дүйлгэн орчуулж болохыг жишээ баримтад тулгуурлан авч үзсэн ч яагаад монгол шүлэгт толгой холбоц чухал вэ? Яагаад европын хэлний шүлэгт сүүл холбоц чухал юм бэ? Эдгээр хэлний шүлгийг харилцан бие биений хэл рүү нь орчуулахад урвуу хамаарал үүсэж байгааг судалсангүй. Тиймд монгол шүлэг судлалд судлах ёстой асуудлын нэг нь энэ асуудал байна.

2. Монгол шүлгийн холбоцыг байрлалаар нь:

-Зэрэгцэх

-Салаавчлах

-Хаших

-Оодон гэж нэрлээд байр, үүргийг тодруулсан ч

яагаад заавал ийм холбоцууд байгааг тодруулж судалсангүй. Энэ нь монгол шүлэг судлалын бас нэг судлуулштай асуудал ажээ.

ЗУРГАА: МОНГОЛ БИЧГИЙН ШҮЛГИЙН ЗАРИМ БАЙДЛААС

Гол өгүүлсэн зүйл: Б.Ринчен энэ хэсэгт шүлгийн бадгийн тухай эхлээд авч үзжээ. Тэрбээр *“Шүлэг яруу найргийн зүйлд бадаг гэдэг нэр бол тухайн шүлэглэлийн санаа гүйцэд нэгэн зүйл биеэ даасан хэсгийг нь нэрлэдэг нэр болой. Шүлгийн бадаг бол хамгийн наад захын хэмжээ нь хоёр шадаар бүтсэн байдаг. Учир иймд, монгол шүлэглэлд шүлгийн хамгийн бага хэмжээ нь хоёр шадаар бүтсэн бадаг байдаг бөгөөд эл хэлбэр нь манай ардын аман зохиолд зүйр цэцэн үгийн зүйлд хошоод хошоод шүлэглэл шадаар бүтсэн: хүн ахтай, дээл захтай, хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа гэх зэргийн цэцэн үгэнд арвин тохиолдох ажээ”* /VIII. 31-32 дугаар тал/ гэж монгол шүлгийн бадгийн тухай судалсан байна. Улмаар *“ардын аман зохиолын эл уламжлал нь бичгийн зохиолд мөн тусаж, хоёр шадат бадаг шүлэг монгол бичгийн зохиолд мөн цөөнгүй хэрэглэдэг ажээ. Энэ сонин онцлог болбол, үг товч, утга дэлгэр болохыг нэн эрхэмлэдэг байсан монгол найруулга зүйн уламжлалаас гарчээ.”* /VIII. 32 дугаар тал/ Монгол шүлгийн үг товч, утга гүн хоёр шад бүхий нэг бадаг шүлгийг хос уянга хэмээн нэрлэж заншжээ.

Монгол бичгийн шүлгийн өөр нэг онцлог нь цэглэл юм. Цэглэл гэж шадын дунд түр завсарлан түдэх үйл хэрэг. Судлаач уг асуудлыг *“Цэг гэж бичигт одоо . тэмдэг тавьж байгаа утгаас гадна ер нь цэг гэж завсарлах гэсэн утгатай тул, цэглэл гэдэг нь шүлэг дуудахад хооронд нь завсарлан дуудах гэсэн утгатай, үүнд, эл цэглэл гэдэг нэрийг орос хэлнээ латин хэлнээс цезура гэж авсан үгтэй утга дүйх монгол нэр ажээ”* /VIII. 34 дүгээр тал/ гэж тодорхойлсон байна. Улмаар монгол шүлгийн бадаглал, цэглэлийн уялдаа холбооны тухай *“нэгэн шадыг монгол шүлэглэлд хоёр тал болгож, нэг бодоход хоёр шадаар бүтсэн хос уянга нь, дөрвөн шад мэт, цэглэлээр тасалсан тал шад нь урьдах тал шадтайгаа сүүлийн тал шад нь толгой холбоостой байдаг зүйл цөөнгүй тохиолдмуй. Үүнээс болж, бас монгол шүлэгт хос уянгын хоёр шад нь дөрвөн шад мэт байдалтайн улмаас, хоёр шад шүлгийг нэгэн бүтэн зүйл гэж уншаад, дотор нь хоёр тал шадаар цэглэн хуваасны нь дөрвөн шад гэж үзэж, хоёр шадыг нь нэгэн бадаг мэт, тэгээд тэр хоёр шадыг цэглэж, дөрвөн шад болгосныг нь бас нэгэн бадаг гэж үзэн, хоёр янзаар дуудан унших зүйл болгодог шүлгийн нэгэн арга байдаг ажээ”* /VIII. 34 дүгээр тал/ гэж монгол шүлгийн бадаглал, шад үүсгэн шүлэглэх аргын онцлог, бололцоог олж харжээ. Монгол шүлэг дэх энэ өвөрмөц арга, бололцооны илэрхийлэл болгож *“Гүнж”* туурь-өгүүлэгийнхээ оршилд шүлэглэл зохиосон байдаг.

Монгол шүлэгт байх өөр нэг онцлог нь шадын дундах үеийн тоо тэнцүү байх асуудал юм. Б.Ринчен *“Монгол шүлгийн учир”* өгүүлэлдээ монгол шүлгийн шад хоорондох үеийн тооны асуудлыг тусгайлан авч судлаад монгол шүлэгт шадуудын үеийн тоог тэнцүүлэх нь *“чухал”* гэсэн шийдэлд хүрчээ. Үүний эсрэг нь үг найруулгын хэмнэлийг чухалчлах ч утга санааг тэргүүлэх үүрэгтэй чөлөөт шүлэг (*vers libre*, /свободный стих/) ч монгол шүлэгт цөөнгүй бичигдсэнийг судалсан байна.

Б. Ринчен “Монгол шүлгийн учир” өгүүллийнхээ сүүлийн хэсэгт Эрдэнийн сан Субашидийн монгол орчуулгын тухай тусгайлан авч үзээд энэ асуудлыг миний багш Владимирцов 1927 онд судлаад “энэ тухай юм бичээрэй” /VIII. 44 дүгээр тал/ гэж захисан захиасыг биелүүлж уг өгүүллийг бичлээ. Бичихдээ “монгол шүлгийн тухай, мөн европын олон хэлнээс шүлэг яруу найргийг монгол болгон буулгах яруу найрагчин орчуулагч нартаа эл хоёр ёсны шүлгийн зүй тогтоолд нийцэх юм олон буйн учир, монголоор шүлэг бичихдээ ч гэсэн, нийтийн ёсонд шүлгийн хэм хэмжээ, холбоц зэргийн чимэг нийлэх зүйл бий, монгол сонгодог шүлгийн зүйлд ч гэсэн, сайн дуун хөрвүүлэгчийн орчуулсан яруу найрагч ч гэсэн, олон улсын шүлгийн ёсны зарчим журам бийг цухас үзүүлэх гэсэн өгүүлэлдээ дурдан гаргах завшаан гарлаа” /VIII. 44 дүгээр тал/ гэж энэ өгүүлэлдээ юуны тухай бичсэнээ товч дүгнэж өгүүлжээ.

Эцэст нь “Европ зүгийн шүлгээс одоо манайхан орчуулдаг болсонд, шүлгийн утгыг орчуулахын зэрэгцээгээр, сайн орчуулагч хүн, шүлгийн бүтэц хэмнэл тэргүүтнийг анзааран нягталж, монголоор буулгахад тэдгээр арга чимгийг нь буулгах чадал манай монгол хэлнээ буйг анзааран бодууштай. Яруу найраг байгаа цагт шүлгийн хэм хэмжээ, бадаг зэргийн олон хэлбэрийг хэрэглэх нь хэзээд байх бий гэж өрнө зүгийн яруу найргийг судлагчин болон яруу найрагчин үздэг, үүнд, монгол яруу найргаа орчуулгын зүйлээр олон улсын сонин хэлбэрийг буулган хэрэглэж монгол яруу найргийг баяжуулахын хамтад монголоороо найруулан бичих шүлгийн зүйлд ч тэдгээр арга барилыг ухамсарлан хэрэглэх цээнд бид хэдийн хүрсэнээ бодууштай” /VIII. 37 дугаар тал/ гэсэн анхааруулга бичсэнийг өгүүлбэ.

Шийдэл: 1. Монгол шүлгийн бадаг, түүний үндсэн нэгж болсон бадгийн тухай судалсан ч яагаад монгол шүлэг заавал хос уянгаар бадагладаг зүй тогтол, мөн чанарыг нарийвчлан судалсангүй. Монгол шүлгийн үндсэн нэгж болох хос уянгын мөн чанар, утга учрыг монголчуудын уламжлалт соёл сэтгэлгээ, иргэншил, ертөнцийг үзэх үзэлтэй холбож нарийвчлан судлах нь монгол шүлэг судлалын чухал ажлын нэг гэдэг гаргалгаа гарч байна. Улмаар монгол шүлэг дэх бадаглал зүйн тухай цогц асуудал эндээс урган гарч ирэхийг үл марталтай.

2. Монгол шүлгийн нэг шад дундаа нэг ба хэд хэдэн цэглэлтэй байдаг байна. Цэглэл ямар нэг үеийн дунд бус заавал үг утга төгссөн газар үүсдэг онцлогтой. Үүний учир холбогдлыг нарийвчлан судлууштай нь илэрхий байна.

ДҮГНЭЛТ

Б.Ринчен “Монгол шүлгийн учир” өгүүлэлдээ монгол хэлнээ гадаадын шүлэг найргийг орчуулахад цаад эх хэл дээрээ байгаа ая айзам, хэм хэмнэл зэрэг үнэт шинжийг нь алдагдуулахгүй буулгах боломж байна гэсэн дүгнэлтэд хүрчээ. Хэдийгээр монгол шүлэгт гадаадын шүлэг найрагт байх ерөнхий арга зарчим байх ч өөрийн гэсэн өвөрмөц онцлог байгааг онцлон авч үзсэн байна. Монгол шүлэг судлалд тулгараад байсан олон асуудлыг монгол ахуй соёл, хэл, уран сайхны сэтгэлгээний хослолын үүднээс тодорхой хэмжээгээр шийдвэрлэж чадсан нь энэ өгүүллийн гол ололт юм. Цаашид энэ өгүүлэлд шийдвэрлэсэн онолын асуудлуудыг практикаар баталгаажуулах, сүүлийн үеийн техник технологийн дэвшлийг ашиглаж улам гүнзгийрүүлэн судлах нь чухал билээ.

Оросын их найрагч А. С. Пушкины “Цаг үе ахиж болном, шинжлэх ухаан, гүн ухаан, иргэншил боловсрон өөрчлөгдөж болном. Яруу найраг нэгэн хэвээрээ аж, үл хуучран эс хувирнам. Түүний зорилго нэгэн, арга барил нь өнөөх л хэвээрээ амуу. Чингээд эртний тэнгэрийн утга, бодис зүй, анагаахуй ухаан, гүн ухааны үлэмжийн

их төлөөлөгчдийн ухагдахуун, бүтээл, нээлт нь хэдийн хуучраад тухай бүр өөр зүйлээр солигдон халагдах ахул, үнэнхүү яруу найрагчийн бүтээл нь хэзээд сонихон шинэхэн бөгөөд үүрд орь залуу хэвээрээ ажам” /Орчуулсан Б. Ринчен/ гэж шүлэг найргийн мөн чанар, онцлог шинжийг хэлсэн энэ үг нэгийг бодогдуулж, хоёрыг сануулах биз ээ. Иймд Б.Ринченгийн “Монгол шүлгийн учир” өгүүлэл монголын судлал тэр дундаа монгол шүлэг судлалд дэвшүүлсэн асуудлаа шийдвэрлэж чадсан чухал ажил болсон нь харагдаж байна.

RESUME

Novelty aspects in article “Etiology of Mongolian verse” by B.Rinchen

As a scholar, who was raised through both the official education system as well as the traditional way of learning cultural, domestic and intellectual wisdom of Mongolian civilization, B.Rinchen remains the main figure for later generation as an embodiment of these values preserved and studied. His article “Etiology of Mongolian verse”, dedicated to the field of Mongolian literature studies, is a towering example of his lasting achievements. It was first published in academic journal “Literature studies”, volume VII, (pages 17-102) and volume VIII (pages 5-50), released by the Academy of Sciences, in 1970.

Verse are artistic means of supreme representation of the national language and mentality. Thus, this article has a great significance as a complex research work done on Mongolian national artistry (descriptive) as well as Mongolian lexical system (particularly, the stylistics). Hence, today, when there are numerous studies done in various fields of poetry, the significance of “Etiology of Mongolian verse” by B.Rinchen is on a rise, whereas a demand for follow-up sophisticated study on its research methodology, academic findings and outcomes, and applied solutions is actual more than ever.

The article “Etiology of Mongolian verse” contains six parts:

I. **Overview.** General teaching about verse composition, special features of Mongolian verse study, comments and tips for potential scholars.

II. **On sounds and words.** General structure of Mongolian language, its phonetic system, how the phonological and lexical unity can enhance the Mongolian verse.

III. **Structure of Mongolian syllables.** 4 ways of syllable formation are discussed, then, compared and correlated with main methods of syllable formation in the world verse.

IV. **On two types of verse.** The Grecian-Latin and Sino-Indian poesy methods are compared with Mongolian verse, and their influences are revealed.

V. **Rhyming.** Various types of rhyming are discussed as distinguishing features of Mongolian verse. Moreover, their qualities are shown on detailed examples and documents.

VI. **Some facts about Mongolian verse.** Selected verse recorded in ancient Mongolian scripts and historic monuments are exemplified.

The scholar aimed to provide a comprehensive outlook on Mongolian verse, as well as to highlight its several distinctive traits. Thus, B.Rinchen correlated features of the Mongolian verse to the historical, cultural, domestic, and psychological background of Mongolians, then, analyzed the phonetic and lexical content, syllable structure and formation, finally, compared them to systems and structures of world poetic practices. The main achievement of the article rests on facts that it provides some urgent issues of the Mongolian study of verse with their resolutions within a unity of Mongolian life, culture and artistic sense. Furthermore, these theoretical outcomes must be practically approved with aid of latest high technology, which shall promote more sophisticated studies to come.

НОМ ЗҮЙ

1. Владимирцов В. Я. *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхасского наречия*. Л., 1929
2. Гаадамба М. *Утга зохиолын онолын үндэс*. Уб., 1989
3. Галбаатар Д. *Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл. Нэвтэрхий толь*. Уб., 2012
4. Галбаяр Г. *Уран зохиол шинжлэлийн лекц*. Уб., 2002
5. Герасимович Л. К. *Монгольское стихосложение*. Л., 1975
6. Гуляев Н. А. *Теория литературы*. М., 1985
7. Дамдинсүрэн Ц. *Гадаад хэлнээс шүлэг орчуулах тухай*. “Шинэ толь” сэтгүүл. №2(14). Уб., 1938
8. Дамдинсүрэн Ц. *Олег цэцний орчуулгын тайлбар*. “Монгол хэл бичгийн тухай” эмхэтгэлд. Уб., 1957
9. Дашдорж Д., Даваасамбуу А. *Монгол шүлгийн дотоод холбоц*. Хэл зохиол судлал. Том-ХІХ. Уб., 1987
10. Жамба Д. *Монгол шүлгийн хэлний тухай*. “Монгол түүх хэлбичиг” сэтгүүл. №3. Уб., 1958
11. Жамбалсүрэн Н. *Монгол шүлэг*. “Утга зохиол” сонин. №8. Уб., 1956
12. Поппе Н. Н. *Халха-монгольский героический эпос*. Л., 1936
13. Ринчен Б. *Монгол шүлгийн учир*. Хэл зохиол судлал. Том-VII-VIII. Уб., 1970
14. Содном Балданы *Монгол шүлгийн арга маяг*. Зохиол судлал. Уб., 2008-2009
15. Туденов Г. *Бурятское стихосложение*. Улан-Удэ., 1958
16. Түдэв Лодонгийн *Шүлэглэсэн туульс*. Бүтээлийн чуулган VI. Уб., 2002
17. Хамгашалов А. *Опыт исследования бурят-монгольского стихосложения*. Улан-Удэ., 1940
18. Хүрэлбаатар Л. *Сонгодог уламжлал, монгол яруу найраг*. Уб., 1989
19. Цэдэв Д. *Монгол яруу найргийн уламжлал шинэчлэл*. Уб., 1974
20. Цэнд Д. *Монгол шүлгийн тогтолцооны асуудалд*. Хэл зохиол судлал. Том-ХІ. Уб., 1975
21. Цэнд Д. *Монгол шүлгийн онцлог*. Хэл зохиол судлал. Том-ХІІ. Уб., 1977
22. Цэрэнсодном Д. *Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал*. Уб., 1977
23. Чимэд Д. *Монгол шүлгийн тогтолцоо*. “Үгийн ид шид” эмхэтгэл. Уб., 1968
24. Энхбаяр С. *Утга зохиолын онол-туурвил зүй*. Уб., 2000
25. Kathleen Morner, Ralph Rausch *Dictionary of Literary Terms*. McGraw Hill. 1998